



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/106

Чингис хот

Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг
ангилалт хийж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аймгийн Засаг даргын А/156 тоот захирамж, Хэрлэн сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.3.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүрэгт үзлэг ангилалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Алтантөгс – Бэлчээр газар тариалан, Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Б.Цолмонбаатар – “Өндөрхаан үржил” ХХК-ийн захирал
Д.Мөнгөнтуяа – Тахилгат тосгоны Хөдөө аж ахуйн мэргэжилтэн

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас олгохыг нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Үржлийн малд үзлэг ангилалт хийж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Алтантөгс)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 21-ны өдрийн 1106
дугаар захирамжийн хавсралт

Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг
ангилалт хийж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлын төсөв

№	Үүлдэр омгийн нэр	Ангилалтанд хамруулах малын тоо	Нэгж үнэ	Ангилалтанд шаардпагдах зардал
	Тал нутгийн цагаан үүлдрийн хонь	200	1500	300.000